

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Аудитор: Ч.Мөнхтогтох

Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

ЗҮҮНГОВЬ СУМЫН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
А.УРАНГОО ТАНАА

додд.од. 25 № УВА-додд/176/НА-СТА-ТМС  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

0200700752

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	11
3.1 Ерөнхий зүйл .....	111
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	111
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	121
3.4 Материаллаг байдал .....	122
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	122
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	123
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	124
3.8 Аудитын гол асуудал .....	144
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	144
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	155
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	155
4. Аудитын илрүүлэлт .....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>15,848,022.32</u></b>	<b><u>162,123,578.52</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	7,896,753.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	7,896,753.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	00.00	7,896,753.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	7,688,674.00
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	208,079.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	635,508.00	113,317,400.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	113,317,400.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	635,508.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	635,508.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	15,212,514.32	40,909,425.52
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	15,212,514.32	40,909,425.52
35460	Хүнсний материал	298,074.00	759,114.00
35470	Бусад хангамжийн материал	14,914,440.32	40,150,311.52
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>424,973,208.24</u></b>	<b><u>571,711,213.20</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	424,973,208.24	571,711,213.20
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	401,221,208.24	547,959,213.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	325,730,269.00	422,997,039.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-44,672,698.56	-47,822,443.54
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,750,000.00	90,150,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,810,000.08	-29,076,666.78
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	157,675,745.04	172,791,174.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	-79,365,172.43	-79,469,029.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,848,679.75	44,848,679.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,035,614.48	-26,659,539.84
39214	Бусад үндсэн хөрөнгө	339,145.00	339,145.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-339,145.00	-339,145.00
39217	Ном	100,000.00	200,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	23,752,000.00	23,752,000.00
39301	Програм хангамж	300,000.00	300,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	23,452,000.00	23,452,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>440,821,230.56</u></b>	<b><u>733,834,791.72</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>12,500,405.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	12,500,405.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	12,500,405.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	6,050,825.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	00.00	6,449,580.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	6,449,580.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>440,821,230.56</u></b>	<b><u>721,334,386.72</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	440,821,230.56	721,334,386.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	355,341,647.11	355,341,647.11
51101	Өмч: - төрийн	355,341,647.11	355,341,647.11
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-134,984,344.67	145,528,811.49
51210	Өмнөх үеийн үр дүн	-134,984,344.67	-134,984,344.67
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	280,513,156.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	220,463,928.12	220,463,928.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>440,821,230.56</u></b>	<b><u>733,834,791.72</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>443,766,729.00</b>	<b>920,599,188.97</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>48,341,030.00</b>	<b>249,870,988.97</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	20,165,000.00	189,906,798.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,165,000.00	189,906,798.97
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	20,165,000.00	189,906,798.97
122	<b>Тусламжийн орлого</b>	28,176,030.00	26,555,490.00
122001	Хандив тусламж /дотоод/	28,176,030.00	26,555,490.00
123	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	00.00	33,408,700.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	33,408,700.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>41,257,399.00</b>	<b>254,442,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,168,300.00	416,285,600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,499,260.00	141,125,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,499,260.00	104,172,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	36,652,600.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	26,758,139.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,758,139.00	00.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	113,317,400.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	113,317,400.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>463,941,984.37</b>	<b>639,793,366.48</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>463,941,984.37</b>	<b>639,793,366.48</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	451,067,621.37	606,107,673.48
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	289,145,909.60	376,040,650.00
210101	Үндсэн цалин	259,401,518.60	333,335,408.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,468,000.00	4,774,000.00
210104	Урамшуулал	19,236,391.00	33,437,242.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,494,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,846,141.40	49,012,564.00
210201	Тэтгэврийн даатгал	25,250,768.75	31,379,269.07
210202	Тэтгэмжийн даатгал	2,868,327.22	3,566,452.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,368,183.60	2,704,840.85
210204	Ажилгүйдлийн даатгал	548,452.38	651,380.39
210205	Эрүүл мэндийн даатгал	5,810,409.45	10,710,620.86
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,356,839.00	31,723,007.00
210301	Гэрэл, цахилгаан	2,478,539.00	2,589,903.00

**Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210302	Түлш, халаалт	22,815,800.00	29,090,104.00
210303	Цэвэр, бохир ус	62,500.00	43,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>23,092,330.00</b>	<b>29,323,858.80</b>
210401	Бичиг хэрэг	1,526,100.00	1,730,633.00
210402	Тээвэр, шатахуун	16,527,030.00	19,264,550.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	954,000.00	1,153,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	903,600.00	1,591,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,954,100.00	5,512,947.00
210408	Бараа материал акталсны зардал	1,227,500.00	70,728.80
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>19,631,986.00</b>	<b>89,255,976.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,599,820.00	82,108,417.00
210502	Хоол, хүнс	3,444,166.00	7,147,559.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,588,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,401,300.00</b>	<b>3,100,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	82,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	889,000.00
210604	Урсгал засвар	1,401,300.00	2,129,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,007,000.00</b>	<b>190,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,007,000.00	190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,220,886.00</b>	<b>753,990.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,300.00	157,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	216,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,700.00	7,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	319,000.00	198,000.00
210807	Газрын төлбөр	329,136.00	78,340.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>53,365,229.37</b>	<b>26,707,627.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,776,560.00	1,476,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,588,669.37	25,231,527.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,874,363.00</b>	<b>33,685,693.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>33,600,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	33,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,874,363.00</b>	<b>85,693.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,874,363.00	85,693.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-20,175,255.37</b>	<b>280,805,822.49</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>6,916.73</b>	<b>292,666.33</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	6,916.73	292,666.33
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-6,916.73</b>	<b>-292,666.33</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-20,182,172.10</b>	<b>280,513,156.16</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>423,601,729.00</b>	<b>617,374,990.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>28,176,030.00</b>	<b>59,964,190.00</b>
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	28,176,030.00	26,555,490.00
122001	Хандив тусламж /дотоод/	28,176,030.00	26,555,490.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	00.00	33,408,700.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	33,408,700.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>395,425,699.00</b>	<b>557,410,800.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	354,168,300.00	416,285,600.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	14,499,260.00	141,125,200.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	00.00	300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,499,260.00	104,172,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	36,652,600.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	26,758,139.00	00.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	26,758,139.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>423,601,729.00</b>	<b>609,478,237.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>423,601,729.00</b>	<b>609,478,237.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>410,727,366.00</b>	<b>575,792,544.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	289,145,909.60	371,979,700.00
210101	Үндсэн цалин	259,401,518.60	321,298,416.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,468,000.00	5,186,000.00
210104	Урамшуулал	19,236,391.00	40,581,284.00
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,914,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	36,846,141.40	46,387,181.00
210201	Тэтгэврийн даатгал	25,250,768.75	33,932,915.01
210202	Тэтгэмжийн даатгал	2,868,327.22	3,113,807.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,368,183.60	2,508,207.02
210204	Ажилгүйдлийн даатгал	548,452.38	621,132.13
210205	Эрүүл мэндийн даатгал	5,810,409.45	6,211,119.84
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,356,839.00	31,723,007.00
210301	Гэрэл, цахилгаан	2,478,539.00	2,589,903.00
210302	Түлш, халаалт	22,815,800.00	29,090,104.00
210303	Цэвэр, бохир ус	62,500.00	43,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,230,630.00	28,860,100.00
210401	Бичиг хэрэг	1,450,000.00	1,642,633.00
210402	Тээвэр, шатахуун	16,527,030.00	19,264,550.00

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	954,000.00	1,153,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	999,600.00	3,199,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	3,499,417.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>25,142,100.00</b>	<b>83,531,866.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,402,200.00	73,911,837.00
210502	Хоол, хүнс	3,151,900.00	7,610,029.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,588,000.00	2,010,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,701,300.00</b>	<b>9,989,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,800,000.00	4,500,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	500,000.00	3,889,000.00
210604	Урсгал засвар	1,401,300.00	1,600,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,007,000.00</b>	<b>190,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,007,000.00	190,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,520,886.00</b>	<b>753,990.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	334,300.00	25,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	216,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	54,700.00	7,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	619,000.00	330,000.00
210807	Газрын төлбөр	329,136.00	78,340.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,776,560.00</b>	<b>2,377,700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,776,560.00	2,377,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,874,363.00</b>	<b>33,685,693.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>33,600,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	33,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>12,874,363.00</b>	<b>85,693.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,874,363.00	85,693.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>7,896,753.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>7,896,753.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>7,896,753.00</b>

#### 2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	355,341,647.11	220,463,928.12	-115,437,680.57	460,367,894.66
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	355,341,647.11	220,463,928.12	-115,437,680.57	460,367,894.66

**Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-20,182,172.10	-20,182,172.10
C08	<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>355,341,647.11</b>	<b>220,463,928.12</b>	<b>-134,984,344.67</b>	<b>440,821,230.56</b>
D01	<b>2021 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>355,341,647.11</b>	<b>220,463,928.12</b>	<b>-134,984,344.67</b>	<b>440,821,230.56</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>355,341,647.11</b>	<b>220,463,928.12</b>	<b>-134,984,344.67</b>	<b>440,821,230.56</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	280,513,156.16	280,513,156.16
D09	<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>355,341,647.11</b>	<b>220,463,928.12</b>	<b>145,528,811.49</b>	<b>721,334,386.72</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	477,630,500.00	468,561,116.00	9,069,384.00	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	477,630,500.00	468,561,116.00	9,069,384.00	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	477,630,500.00	468,475,423.00	9,155,077.00	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	324,377,500.00	323,650,722.00	726,778.00	99.8
210101	Үндсэн цалин	284,690,200.00	284,711,422.00	-21,222.00	100.0

210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	5,186,000.00	622,000.00	89.3
210104	Урамшуулал	28,839,300.00	28,839,300.00	0.00	100.0
210105	Гэрээт ажлын хөлс	5,040,000.00	4,914,000.00	126,000.00	97.5
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,791,100.00</b>	<b>39,980,102.00</b>	<b>3,810,998.00</b>	<b>91.3</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,815,900.00	28,158,699.01	2,657,200.99	91.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,243,800.00	2,972,140.00	271,660.00	91.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,595,000.00	2,365,087.02	229,912.98	91.1
210204	Ажилгүйдлийн даатгал	648,800.00	589,488.13	59,311.87	90.9
210205	Эрүүл мэндийн даатгал	6,487,600.00	5,894,687.84	592,912.16	90.9
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>31,808,700.00</b>	<b>31,723,007.00</b>	<b>85,693.00</b>	<b>99.7</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,800,000.00	2,589,903.00	210,097.00	92.5
210302	Түлш, халаалт	28,688,700.00	29,090,104.00	-401,404.00	101.4
210303	Цэвэр, бохир ус	320,000.00	43,000.00	277,000.00	13.4
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,884,000.00</b>	<b>26,875,250.00</b>	<b>8,750.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	1,650,000.00	1,642,633.00	7,367.00	99.6
210402	Тээвэр, шатахуун	17,280,000.00	17,279,700.00	300.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,154,000.00	1,153,800.00	200.00	100.0
210404	Ном, хэвлэл	100,000.00	100,000.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,200,000.00	3,199,700.00	300.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,499,417.00	583.00	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>36,666,200.00</b>	<b>35,975,652.00</b>	<b>690,548.00</b>	<b>98.1</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26,356,200.00	26,355,623.00	577.00	100.0
210502	Хоол, хүнс	8,300,000.00	7,610,029.00	689,971.00	91.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,010,000.00	2,010,000.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,950,000.00</b>	<b>6,949,000.00</b>	<b>1,000.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	850,000.00	849,000.00	1,000.00	99.9
210604	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,150,000.00</b>	<b>190,000.00</b>	<b>960,000.00</b>	<b>16.5</b>
210702	Дотоод албан томилолт	1,150,000.00	190,000.00	960,000.00	16.5
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,503,000.00</b>	<b>753,990.00</b>	<b>749,010.00</b>	<b>50.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	25,400.00	274,600.00	8.5
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	216,000.00	144,000.00	60.0
210803	Даатгалын үйлчилгээ	148,000.00	63,750.00	84,250.00	43.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,100.00	7,500.00	52,600.00	12.5

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	33,000.00	44,000.00	42.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	464,900.00	330,000.00	134,900.00	71.0
210807	Газрын төлбөр	93,000.00	78,340.00	14,660.00	84.2
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4500000.00	2377700.00	2,122,300.00	52.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.00	2,377,700.00	2,122,300.00	52.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	444,221,800.00	442,841,090.00	1,380,710.00	99.7
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	416,285,600.00	416,285,600.00	0.00	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	416,285,600.00	416,285,600.00	0.00	
<b>122</b>	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	27,936,200.00	26,555,490.00	1,380,710.00	95.1
122001	Хандив тусламж /дотоод/	27,936,200.00	26,555,490.00	1,380,710.00	95.1
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	7,688,674.00		0.0
	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	24.00	24.00		
620001	Удирдах ажилтан	01.00	01.00		
	Удирдах ажилтан	1.00	1.00		
620003	Үйлчлэх ажилтан	04.00	4.00		
620004	Гэрээт ажилтан	00.00	1.00		
	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00		
	Үйлчлэх ажилтан	4.00	4.00		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл / төгрөгөөр /
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>140,917,121.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>140,917,121.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		107,317,121.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		48,328,978.00
210101	Үндсэн цалин		36,586,994.00
210104	Урамшуулал		11,741,984.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		6,407,079.00
210201	Тэтгэврийн даатгал		5,774,216.00
210202	Тэтгэмжийн даатгал		141,667.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		143,120.00
210204	Ажилгүйдлийн даатгал		31,644.00
210205	Эрүүл мэндийн даатгал		316,432.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		1,984,850.00
210402	Тээвэр, шатахуун		1,984,850.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>		47,556,214.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		47,556,214.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		3,040,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		3,040,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	0.00	33600000.00

2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		33,600,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		33,600,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	134914600.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		134,914,600.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		300,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		97,962,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		36,652,600.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 14 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төв нь Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулж үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 463,941.9 мянган төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 639,793.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 6,397.9 мянган төгрөгийн 80 хувиар буюу 5,118.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гарах цагалбарт хугацаа болоогүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 293,013.5 мянган төгрөгөөр буюу 66.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	7,896.7	7,896.7
Авлага	635.5	113,317.4	112,681.8
Бараа материал	15,212.5	40,909.4	25,696.9
Үндсэн хөрөнгө	424,973.2	571,711.2	146,738.0

<b>Нийт хөрөнгө</b>	<b>440,821.2</b>	<b>733,834.8</b>	<b>293,013.5</b>
Өр төлбөр	0.0	12,500.4	12,500.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	440,821.2	721,334.4	280,513.1
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>440,821.2</b>	<b>733,834.8</b>	<b>293,013.5</b>

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,896.7 мянган төгрөг болж 7,896.7 мянган төгрөгөөр өссөн нь үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 113,317.4 мянган төгрөг болж 112,681.8 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт дутуу ирснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 40,909.4 мянган төгрөг болж 25,696.9 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлаас шалтгаалан бусад хангамжийн материал, эм боох материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Оны эцэст бараа материалын нөөц үүсгэсэн нь ирэх онд Ковид-19 цар тахалд зарцуулахаар байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 721,334.3 мянган төгрөг болж 280,513.1 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон үнэ төлбөргүй авсан хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн дансанд урсгал төсвийн худалдан авалтаар 1,807.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 170,455.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 721,334.3 мянган төгрөг болж 280,513.1 мянган төгрөгөөр өссөн нь шинээр нэмэгдсэн үндсэн хөрөнгө, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 476,832.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээж авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих орлого байна. Энэ нь Ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 175,851.3 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамжийн бараа материалын зардал, нормативт зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахалтай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүнд хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 477,630.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн санал 477,630.5 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийж 2,836.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 477,630.5 мянган төгрөгөөр баталсан байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 477,630.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 416,285.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 33,408.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 27,936.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 416,285.6 мянга, орон нутгийн төсвөөс 33,408.7 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 27,936.2 мянга, нийт 477,630.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 468,561.1 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,896.7 мянган төгрөг байна.

Төсвийн зардлын гүйцэтгэл 468,561.1 мянган төгрөг буюу 98.1 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 141,125.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс урамшууллын зардалд 48,328.9 мянга, НДШ зардалд 6,407.0 мянга, хангамж, бараа материалын зардал 1,984.8 мянга, нормативт зардал 47,556.2 мянга, эд хогшил худалдан авах зардал 3,040.0 мянга, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 33,600.0 мянга, нийт 140,917.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

## **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг

тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож мэдээлсэн 11, хугацаа болоогүй 1 мэдээлэл байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Зүүнговь сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын 113,317.4 мянган төгрөгийн авлага тусгагдсан байна. 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР-  /М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Ч.МӨНХТОГТОХ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр